



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** АНУ-ын зах зээлийн индексүүд өөр өөр үзүүлэлттэй хаагдлаа. Худалдааны маргааны асуудал намдаж, аж үйлдвэрийн салбарын компаниуд, тэр дундаа агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын хувьцааны ханш өсжээ.

“Facebook” компани 2-р улирлын санхүүгийн тайлангаа зарлаж, тус компанийн хувьцааны ханш 19 хувиар унав. “Facebook” компанийн зах зээлийн үнэлгээ 120 тэрбум ам.доллараар буурсан явдал нь зах зээлийн түүхэнд онцлох үйл явдал болжээ. 2018 оны 2-рулиралд “Facebook” компанийн орлого 2017 оны мөн үетэй харьцуулахад 40 хувиар өсөн 13.2 тэрбум ам.доллар хүрсэн ч энэ нь хөрөнгө оруулагчдын хүлээлтээс дор байв. Тус компани цаашдаа мэдээллийн нууцлал хадгалах чиглэлээр үйл ажиллагааныхаа зардлыг нэмнэ хэмээн мэдэгджээ.

АНУ, Европын холбоо хоёр худалдааны дайнд цэг тавьж, Атлантыг дамнасан худалдааны саадыг арилгах, Дэлхийн худалдааны байгууллагыг шинэчлэх чиглэлд хамтран ажиллахаа тунхаглав. Тэд автомашинаас бусад аж үйлдвэрийн бүтээгдэхүүний тариф болон бусад хориг саадыг арилгахаар тохиролцжээ.

Энэ оны 2-р улиралд АНУ-ын ДНБ сүүлийн 4 жилийн хугацаанд үзэгдээгүй өсөлт үзүүлж, өнгөрсөн оны мөн үеэс 4.1 хувиар өсчээ.

**Европ:** АНУ, Европын холбоо хоёр худалдааны дайнд цэг тавьсан болон хувьцаат компаниудын 2-р улирлын санхүүгийн тайлангууд хүлээлтээс өндөр үзүүлэлттэй байсан зэрэг хүчин зүйлс нь Европын компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдахад нөлөөлжээ. Мөн Европын төв банк бодлогын хүүгээ өөрчлөхгүй байх шийдвэр гаргасан байна.

**Япон:** Японы компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдлаа. АНУ гадаад худалдааны протекционист бодлого явуулж эхэлсэнтэй холбоотойгоор Япон улс болон Европын холбоо чөлөөт худалдааны гэрээнд гарын үсэг зурлаа. Энэхүү гэрээний хүрээнд Европын холбоо Япон улсаас нийлүүлдэг авто машин болон түүний эд ангид ногдуулсан 10 хувийн гаалийн татварыг чөлөөлж, харин Япон улс Европоос импортоор орж ирдэг дарс, бяслаг зэрэг зарим хүнсний бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөллөө.

Үүний үр дүнд Японы авто машин үйлдвэрлэгчдийн экспортын борлуулалт өсч, харин сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид зах зээлд эзлэх байр сууриа Европын бараа бүтээгдэхүүнд алдана хэмээн үзэж байна.

Японы төв банк Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөжийг 0 орчим хувьд барих зорилгоор урт хугацаат бондыг худалдан авч байсан бол сүүлийн саруудад худалдан авалтаа тогтмол багасгажээ. Даваа гарагт Японы төв банк мөнгөний бодлогын хөтөлбөрөө тогтвортой байлгах зорилгоор бодлогын хүүгийн түвшинг өөрчлөх талаар хэлэлцэж байгаа талаар мэдээлэв.

**БНХАУ:** АНУ, БНХАУ-ын худалдааны маргааны асуудал даамжирч, юанийн ханш сулран 2015 оноос хойшхи хамгийн доод түвшиндээ хүрлээ. Хятад улсын эдийн засгийн өсөлт удааширч, АНУ-ын БНХАУ-ын бараа бүтээгдэхүүнд гаалийн татвар ногдуулах арга хэмжээ энэ оны 8-р сараас хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан юанийн ханш 6-р сарын дунд үеэс эхлэн суларчээ. БНХАУ нь АНУ-аас үзүүлж буй эдийн засгийн цохилтыг зөвлүүлэх зорилгоор юанийн ханшийг чангатгах арга хэмжээ авахгүй байгаа ажээ. Юанийн ханшийн сулрал тус улсын экспортын барааг дэлхийн зах зээлд үнээр өрсөлдөх боломжийг олгож байна.

**Эх сурвалж:** Reuters, Troweprice

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,345.19	-1.47% ▼
Dow Jones	АНУ	25,451.06	1.57% ▲
S&P 500	АНУ	2,818.82	0.61% ▲
Nasdaq	АНУ	7,737.42	-1.06% ▼
S&P/TSX	Канад	16,393.95	-0.25% ▼
FTSE 100	Их Британи	7,701.31	0.29% ▲
S&P/ASX 200	Австрали	6,300.20	0.23% ▲
Nikkei 225	Япон	22,712.75	0.07% ▲
Hang Seng	Хонг Конг	28,804.28	2.05% ▲

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	110.57
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.61
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.51
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	113.01
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.44
TDBM' 2020	USD	9.3%	106.48

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.077	0.01 ▲
Libor 3M	2.342	0.00 ▲
Libor 6M	2.530	0.01 ▲
Libor 1YR	2.821	0.02 ▲
US 6M Bond	2.175	0.04 ▲
US 2YR Bond	2.669	0.08 ▲
US 3YR Bond	2.758	0.08 ▲
US 5YR Bond	2.843	0.08 ▲
US 10YR Bond	2.960	0.07 ▲

### Валютын ханш /төг/

Валют	2018.07.27	Өөрчлөлт
USD	2,464.44	0.11% ▲
CNY	361.81	-0.34% ▼
EUR	2,870.21	0.16% ▲
RUB	39.11	0.82% ▲
KRW	2.21	1.84% ▲
JPY	22.20	1.42% ▲

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,222.99	-0.93% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	15.49	-0.32% ▼
Зэс	USD/lb.	280.45	1.63% ▲
Нүүрс	USD/MT	115.43	1.84% ▲
WTI газрын тос	USD/bbl.	68.98	1.14% ▲
Brent газрын тос	USD/bbl.	74.33	1.71% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.79	2.20% ▲

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018.VI	7.20%
Бодлогын хүү	2018.VI	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VI	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VI	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VI	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VI	18.00%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VI	10.20%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 40 компанийн 794.1 сая төгрөгийн 6,513,364 ширхэг хувьцаа арилжигдав.


“ЛэндМН ББСБ” /LEND/ компанийн хувьцаа 18.05%-аар буюу хамгийн ихээр өсч 69.05 төгрөгт хүрч хаагдсан бол “Увс чацаргана” /CHR/ компанийн хувьцаа 20.59%-аар буурч 675 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 2,320 ширхэг үнэт цаас 241.2 сая төгрөгөөр арилжаалагджээ.


7-р сарын 27-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,361.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,345.19 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.47%-аар буурсан байна.

## MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,036.3
Зах зээлийн үнэлгээ	2,361,517.0

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,345.19	-1.47% ▼
MSE I индекс	9,331.27	-2.47% ▼
MSE II индекс	9,506.69	-0.68% ▼

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	5,957,718	379,768,598
Таван толгой	10,881	97,619,300
Монгол базальт	207,642	77,567,372
АПУ	113,796	66,062,297
Говь	2,192	52,995,760

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
ЛэндМН ББСБ	69.06	18.05% ▲
Хүннү менежмент	185.00	12.77% ▲
Ар баянхангай	900.00	12.50% ▲
Усжуулах	600.00	12.49% ▲
Хөх ган	110.00	9.90% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Увс чацаргана	675.00	-20.59% ▼
Хишиг уул	700.00	-13.58% ▼
Махимпекс	2,601.00	-12.95% ▼
Бөөний худалдаа	410.00	-12.67% ▼
Таван толгой	8,530.00	-12.06% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Голомт Капитал	783,522,969
БиДиСек	585,759,133
Мирэ Эссет Секьюритис Монгол	417,359,009
Ти Ди Би Капитал	148,754,683
Бумбат-Алтай	132,498,736

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	580.00	617,225
Таван толгой	8,500.00	449,234
МИК	10,990.00	227,595
Говь	24,200.00	188,787
Сүү	217.19	74,713

## ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-11/04/19-A0230-18	1,000	103,280,000	103,280	103,280	104	18.000%
2	ZGEB-BD-11/04/19-A0230-18	1,320	138,969,600	105,280	105,280	104	18.000%

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
4	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
10	SUL	Жуулчин дюти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байранд
11	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
12	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байранд
13	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
14	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
15	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
16	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
17	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
18	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
19	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байранд
20	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байранд
21	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
22	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
23	TAN	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
24	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
25	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байранд
26	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Уужим хангай” ХК-ийн үнэт цаасны арилжааг нээхээр боллоо

Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 76 дугаар тогтоолоор “Уужим хангай” ХК-д “Стандарт агрикалчер групп” ХХК-ийг нэгтгэж 13,735,752 ширхэг хувьцааг “Стандарт капитал” ХХК-д бүртгэсэн тул Хорооны улсын байцаагчийн албан шаардлагын дагуу “Уужим хангай” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн нээхээр боллоо.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Монгол Базальт” ХК-ийн 1-р хагас жилийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд

Чулуун хөвөн үйлдвэрлэгч “Монгол базальт” ХК энэ оны 5-р сард IPO хийн МХБ-ийн II ангилалд бүртгүүлсэн билээ. Энэ долоо хоногт тус компани 1-р хагас жилийн санхүүгийн тайлангаа олон нийтэд танилцуулж, ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулав.

Компанийн орлогын тайланг үзвэл борлуулалтын орлого 639.47 сая төгрөгт, харин борлуулсан бүтээгдэхүүний өртөг 281 сая төгрөгт хүрчээ. Ингэснээр нийт ашиг 358.3 сая төгрөгтэй тэнцлээ.

Тус компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс харвал 6-р сард IPO хийн татан төвлөрүүлсэн хөрөнгөөс урт хугацаат зээлээ бүрэн төлж дуусгасан ба одоогийн байдлаар тоног төхөөрөмж шинээр худалдан авалгүй хадгаламжинд байршуулснаар 42.6 сая төгрөгийн хүүгийн орлого олжээ.

Борлуулалт, маркетингийн зардал огцом өсөхөд IPO гаргахтай холбоотой 423.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий нэг удаагийн зардлууд голчлон нөлөөлсөн хэмээн “Монгол базальт” ХК-ийн гүйцэтгэх захирал Л.Ариунболд мэдээлсэн. Ингэснээр компанийн тайлант үеийн цэвэр алдагдал 190.7 сая төгрөгтэй тэнцэж байна.

Бараа материалын нөөц 2018 оны эхний хагас жилийн байдлаар 979.1 сая төгрөг болжээ. Тус компанийн мэдээлснээр чулуун хөвөн худалдаалах бизнес улирлын шинж чанартай байдаг учраас оны эхний хагас жилд бараа материалын түүхий эдийг татаж бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлдэг, харин 2-р хагас жилд 1-р хагас жилийн нөөцийг борлуулан, ашиг нэмэгддэг гэлээ.

“Монгол базальт” ХК одоогийн байдлаар чулуун хөвөн худалдах 1.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2 гэрээ шинээр байгуулсан, мөн 1.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2 гэрээг байгуулах нь тодорхой болсон ба 2.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2 гэрээ хүлээгдэж байгаа талаар мэдээлсэн. Мөн тендерт оролцох боломж нээгдсэн ажээ.

Цаашдаа компани маркетингийн тал дээр түлхүү анхаарч, маркетингийн зардлаа нэмэх төлөвлөгөөтэй байна. Үүний хүрээнд “Монгол базальт” ХК энэ оны 9-10 сард “Мишээл экспо” төвд хэрэглэгчийн сургалт, сурталчилгааны шоурум нээхээр ажиллаж байна. Гадаад зах зээлийн хувьд энэ оны 10-р сард ОХУ-д зохион байгуулагдах “International Basalt Forum 2018”, 11-р сард БНХАУ-д зохион байгуулагдах “TIM Expo Shanghai”-д оролцох аж. Мөн тус компани Дархан, Эрдэнэт хотуудад салбар нээн ажиллах урт хугацааны зорилттой байгаа юм.

**Эх сурвалж:** Ти Ди Би Капитал ҮЦК

### “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдээс хувьцааг худалдан авах тендер санал

Монгол Улсын Засгийн Газар нь 2018 оны 04 дүгээр сарын 19-ны өдрөөс “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцааны хяналтын багцыг дангаараа эзэмшигч болсон тул “Компанийн тухай” хуулийн 57.1, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 22.1.2 болон СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-ыг үндэслэн үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн 94.67 хувь буюу 24,491,390 ширхэгээс бусад хэсгийг худалдан авах санал гаргаж байна. Үүнд:

Худалдан авахаар санал гаргасан хувьцааны тоо ширхэг: 1,378,886 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2018.07.09

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2018.09.19

Нэгж хувьцааны худалдан авах үнэ: 542.00

Хувьцааг худалдан авах төлбөрийг гүйцэтгэх хугацаа: 2018.09.20

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “БиДиСек” ХК-ийн 2018 оны хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гарлаа

1991 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж буй “БиДиСек” ХК 2018 оны эхний хагас жилд шинээр 1,636 харилцагч нэмж, нийт 200,000 гаруй харилцагчтай болжээ. 2018 оны 4-р сарын 2-ны өдрийн байдлаар тус компанийн нийт хувьцааны 23.78 хувийг Герман улсын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бол гүйцэтгэх захирал болох Д.Даянбилгүүн 19.26 хувийг эзэмшдэг аж.

2018 оны 1-р хагас жилийн байдлаар “БиДиСек” ХК-ийн андеррайтерийн үйл ажиллагааны орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр тус компанийн үйл ажиллагааны орлого 4.3 тэрбум төгрөгт хүрлээ. Харин ерөнхий ба удирдлагын зардал 1.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 2.6 тэрбум төгрөг болов. Ингэснээр 2018 оны эхний хагас жилийн байдлаар тус компанийн цэвэр ашиг 2.7 тэрбум төгрөгтэй тэнцлээ. Энэ нь 2017 оны мөн үетэй харьцуулахад 86.6 хувь буюу 1.3 тэрбум төгрөгөөр өссөн дүн юм.

Компанийн санхүүгийн хөрөнгө нэмэгдэж, нийт хөрөнгө 20.5 тэрбум төгрөгт хүрчээ. “БиДиСек” ХК-ийн богино хугацаат 2.1 тэрбум төгрөг, харин эздийн өмчийн дүн 18.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар “БиДиСек” ХК МХБ-ийн арилжаагаар нийт 20.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий гүйлгээг гүйцэтгэсэн ба одоогийн байдлаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх 2, үнэт цаас шинээр бүртгүүлэх 2 гэрээнд гарын үсэг зурсан байгаа ажээ. Тус компани Монгол улсын анхны давхар бүртгэл болох “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн” ХК-ийн хувьцааг энэ оны 6-р сард МХБ-д бүртгүүлж 2.56 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Мөн зөвлөх үйл ажиллагааны хүрээнд хувьцаа эзэмшигчдийн хурал болон сургалт зохион байгуулах, компанийн хэлбэрийг өөрчлөх зэрэг үйл ажиллагааг явуулж нийт 5 компанитай гэрээ байгуулсан аж.

**Эх сурвалж:** Ти Ди Би Капитал ҮЦК

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Зэсийн зах зээл 50 мянган тоннын илүүдэлтэй байна

Зэсийн нийлүүлэлт эрэлтээ давж, илүүдэл нь 50 мянган тоннд хүрснийг Дэлхийн зэсийн судалгааны групп буюу ICGS мэдээллээ. Энэ оны эхний дөрвөн сард олон улсын зэсийн үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өсчээ. Уг түүхий эдийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Чилийн гарц энэ хугацаанд 15 хувиар өссөн байна. Тус улсад байрладаг, дэлхийн зэсийн хамгийн том уурхай болох Эскондидагийн үйлдвэрлэл саарсан ч, Коделко уурхайнх нэмэгдсэн нь Чилийн гарцыг өсгөсөн байна. Эскондида уурхайн ажилчид, хөрөнгө оруулагчдын маргаан эцэслэвэл Чилийн зэсийн гарц цаашид ч чангарах төлөвтэй байна.

Дэлхийн зэсийн тэргүүлэх уурхай ийн хэвийн ажиллах нөхцөл нь бүрдэж буй бол нөөц болон үйлдвэрлэлээр хоёрдугаарт бичигддэг Индонезийн Грасбергийн уурхайн үйл ажиллагаа хэдийнэ хэвийн болсон. Экспортын хязгаарлалттай нүүр тулсан Грасберг уурхайн олборлолт эргэн сэргэснээр Индонезийн гарц 2017 оныхоос даруй 50 хувиар нэмэгдсэнийг ICGS онцолжээ.

Чили, Индонез зэрэг зах зээлийн гол тоглогчдоос гадна Бүгд Найрамдах Ардчилсан Конго болон Замби улсын гарц 11-16 хувиар нэмэгджээ. Ийнхүү худалдааны болон ажиллах хүчний сорилттой нүүр тулаад байсан зэсийн нийлүүлэлт эргэн сэргэж байна. Сүүлийн сар гаруйн хугацаанд зэсийн ханш АНУ, БНХАУ-ын худалдааны зөрчлийн сүүдэрт дарагдаж, нэг жилийн доод цэгтээ хүрчихсэн байхад зэсийн нийлүүлэлт илүүдэж буй нь ханшийг унах эрсдэлтэй ажээ.

Худалдааны маргаан цаашид ч улам даамжрах төлөвтэй. Ингэснээр зэсийн гол худалдан авагч болох Хятад, Америкийн эрэлтийн өсөлтөд ч эрсдэл үүснэ. Энэ хэрээр зэсийн ханш дахиад л дарамтад орно гэсэн үг. Гэтэл зэсийн ханшийг доош татах дахиад нэг хүчин зүйл байгааг шинжээчид онцолж эхлэв. Энэ бол нэг жилийн доод цэгт хүрээд буй юанийн ханш болон түүнээс хамаарсан зэсийн үнэ. Юань, зэс хоёр нягт харилцан хамааралтай аж. Тухайлбал, одоогоос гурван жилийн өмнө, ам.доллартай харьцах юанийн ханш яг өнөөгийнх шиг уруудаж, хоёр хувиар суларчээ. Гэтэл үүнийг даган зэсийн ханш 400 ам.доллараар буурч байсан аж. Тодруулбал, тонн зэсийн жишиг ханш 5,050 ам.доллараас 4,650 болтлоо буурсан байх юм.

Мөн Нью-Йоркийн Comex бирж дэх зэсийн ханшийн 10 өдрийн хөдөлгөөний юаниас хамаарах хамаарал нь 90 хувьтай байсныг ING тооцоолжээ. Дэлхийн зэсийн нийт нийлүүлэлтийн 40 хувийг ганцаараа залгадаг, энэ зах зээлийн хамгийн том хэрэглэгч Хятад улсын мөнгөн тэмдэгтийн зэсийн ханшид нөлөөлөх нөлөө ийм хүчтэй байна. Гэтэл 7-р сараас хойш юанийн ханш ам.долларын эсрэг 5 хувиар буурсан. Юань нь зөвхөн ам.доллар гэлтгүй бусад валютын эсрэг сулраад байгаа. Үүнтэй зэрэгцээд өнгөрсөн даваа гарагт Хятадын төв банк 502 тэрбум юанийг (74 тэрбум ам.доллар) банкны системдээ нийлүүлээ. Зах зээлд дэх юанийн нийлүүлэлт ийн нэмэгдсэнээр юанийн хагш ам.долларын эсрэг 0.6 хувиар суларчээ. Энэ бол өнгөрсөн оны 6-р сараас хойших хамгийн доод цэг. Цаашид юанийн чөлөөт уналтыг дагаад зэсийн ханш хаана ч газардаж мэдэхээр байна.

**Эх сурвалж:** Засгийн газрын мэдээ сонин

## БУСАД МЭДЭЭ

### Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 8.3 тоннд хүрчээ

Монголбанкны алтны худалдан авалт энэ сарын 20-ны байдлаар 8.3 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 14 хувийн өсөлттэй гарсан байна.

Монголбанкнаас “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран олон ажлыг зохион байгуулж, мэдээллийг шуурхай хүргэн ажиллаж байна. Мөн алтны үнийг өдөр бүр Лондонгийн металын биржийн үнээр шинэчлэн тогтоож, олон улсын зах зээлийн ханшаар худалдан авч буй юм.

**Эх сурвалж:** Montsame.mn

### Төсвийн нийт тэнцэл 12.9 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний хагас жилд 4.1 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4.1 их наяд төгрөгт хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2017 оны эхний хагас жилд 676.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байсан бол 2018 оны эхний хагас жилд 12.9 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Татварын нийт орлого 3.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 842.6 (29.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд тусгай зориулалтын орлого 0.4 (6.9%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч нэмэгдсэн өртгийн албан татвар 240.3 (33.7%) тэрбум төгрөг, орлогын албан татвар 219.6 (31.2%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 132.8 (63.7%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 92.7 (15.1%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 89.9 (41.9%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 53.4 (18.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 80.4 хувийг татварын орлого, 10.5 хувийг татварын бус орлого, 6.8 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 2.3 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2018 оны эхний хагас жилд 4.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 172.2 (4.4%) тэрбум төгрөгөөр өсөхөд хөрөнгийн зардал 120.4 (23.4%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч урсгал зардал 196.7 (5.9%) тэрбум төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 95.9 (2.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 86.0 хувь, хөрөнгийн зардал 9.6 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 4.4 хувийг эзэлж байна.

**Эх сурвалж:** Montsame.mn

### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.